COVID-19

ХАТУУ ХӨЛ ХОРИОНЫ ҮЕИЙН БИЗНЕСИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

2020.11.26

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ 2
ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ, САНАЛ 3
Нэг. Хатуу хөл хорионы бизнест үзүүлж буй нөлөө 5
Үйл ажиллагаанд үзүүлж буй нөлөө 5
Ажлын байр, цалинд үзүүлж буй нөлөө 7
Аж ахуйн нэгжийн санхүүд үзүүлж буй нөлөө 10
Нэгдүгээр хэсгийн дүгнэлт 13
Хоёр. Тулгарч буй хүндрэл ба шаардлагатай дэмжлэг 15
Тулгарч буй хүндрэл 15
Шаардлагатай дэмжлэгүүд 15
Хоёрдугаар хэсгийн дүгнэлт 18
Гурав. Оролцогчдын мэдээлэл 19

ӨМНӨХ ҮГ

Ковид 19 вирусийн халдвар цар тахлын хэмжээнд хүрч, дэлхий дахинаа олон зуун сая хүн халдвар авч, олон сая хүн халдварын улмаас амь насаа алдан улс орнууд хүний эрүүл мэнд амь нас, эдийн засгийн маш том сорилттой тулгарч, асар их хохирол амсаж байна.

МҮХАҮТ-аас вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх хорио цээрийн арга хэмжээ авсан цагаас бизнест үзүүлж буй нөлөөний судалгааг явуулж, судалгааны үр дүнд үндэслэн “Эдийн засгийн эрсдэлийг удирдах багц санал”-ыг боловсруулан Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайд, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл болон гол Яамдын сайд нарт танилцуулсан билээ. Мөн ажлын байранд болон зарим салбарт үзүүлж байгаа нөлөөлөл, учирч болох эрсдэл, шаардлагатай арга хэмжээний талаар судалгаануудыг явуулж үр дүнг цаг тухайд нь мэдээлж ирсэн.

МакКинзи глобал институтээс гаргасан эрүүл мэнд ба эдийн засгийг хамгаалах хоёр чиглэлийн арга хэмжээний бага, дунд, өндөр зэргээс хамаарч улс орнуудын эдийн засгийн сэргэлт ямар байх төсөөллөөс харахад Монгол улсын эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээ өндөр, эдийн засгаа хамгаалах арга хэмжээ бага түвшинд гэж авч үзвэл эдийн засаг огцом унаж эргээд сэргэх үйл явц нилээд урт хугацаанд үргэлжлэх дүр зурагтай байна.

Бусад орны туршлагаас харахад, халдварын тархалтын түвшингээс хамааран үе шаттай хязгаарлалтын арга хэмжээнүүдийг тодорхойлон, ямар шатанд ямар салбарууд хэрхэн ажиллахыг тодорхой болгож, эдийн засгаа үе шаттайгаар дахин нээх, эдийн засгийн үйл ажиллагааг хэвийн байдалд оруулах төлөвлөгөө гаргаж ажилласан бөгөөд гол салбаруудын үйл ажиллагааг сэргээх, ажлын байрыг хадгалах, цар тахлын нөлөөлөлд ихээр өртсөн бизнест тусламж дэмжлэг үзүүлэх санхүүгийн багц арга хэмжээг авч хэрэгжүүлжээ.

Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, эдийн засаг бизнесийг сэргээх энэ хоёр асуудлын тэнцвэрийг зөв олж шийдвэр гаргах шаардлагатай энэ чухал цаг үед “Хатуу хөл хорионы үеийн бизнесийн нөхцөл байдал судалгаа”-г явуулж бизнес эрхлэгчдийн дунд явуулж, тайланг та бүхэнд танилцуулж байна. Нийгэм эдийн засгийн хувьд учирсан энэхүү том сорилтыг даван туулах, эрсдэлийг удирдах зөв оновчтой шийдвэр гаргахад тань энэхүү тайлан тус дэм болно гэж найдаж байна.

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ, САНАЛ

МҮХАҮТ-аас 2020 оны 11 дүгээр сарын 23-25-ны өдрүүдэд хатуу хөл хорионы үед бизнесийн нөхцөл байдлыг үнэлэх зорилгоор Улаанбаатар хот, орон нутгийн бизнес эрхлэгчдийн дунд цахим хэлбэрээр 2020 оны 11 сарын 23-25-ны өдрүүдэд судалгааг явуулаж 3530 аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдийг хамруулав. Судалгаанд оролцогчдыг салбараар харвал, 27% нь үйлчилгээ, 18% нь дотоод худалдаа, 9% гадаад худалдаа, барилга, 8% нь хүнсний бус үйлдвэр, 7% нь хүнсний үйлдвэр байна.

Хатуу хөл хорио тогтоосон энэ хугацаанд судалгаанд оролцогсдын 66 хувь нь бүрэн зогссон, 22 хувь нь хязгаарлагдмал хүрээнд, 10 хувь нь зайнаас ажиллаж байгаа гэсэн бол дөнгөж 2 хувь нь хэвийн үйл ажиллагаагаа явуулж байна гэсэн бөгөөд 53 хувь нь 1 сараас бага хугацаанд, 31 хувь 1-3 сарын хугацаанд ажлын байрны тоог өөрчлөхгүй хадгалж үлдэх боломжтой гэсэн хариулт өгсөн байна.

Хатуу хөл хорионы дэглэмийн хугацааг 3 шатлалтайгаар авч, ажлын байр дах нөлөөллийг тодруулахад 11 сарын 12-ны өдрөөс хөл хорионы дэглэм тогтоосноос хойш харин судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдийн 67 хувь нь ажлын байрны тоонд ямар нэг өөрчлөлт оруулаагүй, 25 хувь нь ажлын байрны тоог бууруулсан ба нийт **7,645** ажлын байр цөөлжээ. Энэ тоог нийт идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн тоогоор тооцоолбол одоогоор 152,900 ажлын байр цөөрсөн гэж хэлж болно.

Хатуу хөл хорионы дэглэм 12 сарын 1-ний өдрөөс цааш нэг сараар сунгагдсан тохиолдолд оролцсон бизнес эрхлэгчдийн 46% нь ажлын байрны тоог бууруулах бөгөөд энэ нь **21,630** ажлын байрыг бууруулах, 3 сараар сунгагдсан тохиолдолд нийт судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 52 хувь нь ажлын байрны тоог бууруулах ба нийт **25,253** ажлын байр цөөлнө гэж хариулжээ. Үүнийг идэвхтэй ажиллаж байгаа аж ахуй нэгжийн тоогоор авч үзвэл, хөл хорио нэг сараар сунгагдсан тохиолдолд 430 мянга гаруй, гурван сараар 505 мянга гаруй ажлын байрыг цөөлөхөөр байна.

Хатуу хөл хорионы дэглэм тогтоосонтой холбоотойгоор аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдэд үүсээд буй хүндрэл, бэрхшээлийн хувьд 24 хувь нь ажлын байраа хадгалах, ажиллагсдын цалин тавих, 21 хувь нь бизнесийн зээлийн эргэн төлөлт хийх, 17 хувь нь хөл хориотой холбоотой төр, засгаас гаргаж буй шийдвэрийн ойлгомжгүй, уялдаа холбоогүй байдал гэсэн бол 16 хувь нь түрээсийн төлбөрөө төлөх нь хамгийн хүндрэлтэй байна гэж хариулжээ.

Харин хатуу хөл хорионы үед аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдэд Засгийн газраас ямар төрлийн дэмжлэг шаардлагатай байгааг тодруулахад давхардсан тоогоор судалгаанд оролцогсдын 55 хувь нь татвар (НӨАТ)-ын хөнгөлөлт, чөлөөлөлт, 52 хувь нь НДШ-ийн төлбөрийг хөнгөлөх, төлөх хугацааг хойшлуулах, 50 хувь нь бизнесийн үйл ажиллагааг тодорхой хувиар үргэлжлүүлэх боломж олгох, 39 хувь нь зээлийн хүүг бууруулах, 38 хувь нь аж ахуйн нэгжийн түрээсийн зардлыг төрөөс санхүүжүүлэх шаардлагатай байна гэсэн байна.

Хөл хорионы дэглэм дууссаны дараа бизнесийн үйл ажиллагаагаа сэргээхэд Засгийн газраас ямар дэмжлэг, шийдэл шаардлагатай байгааг тодруулахад судалгаанд оролцсон аж ахуй нэгж, бизнес эрхлэгчдийн 56 хувь нь татвар (НӨАТ)-ын хөнгөлөлт, чөлөөлөлт, 54 хувь нь зээлийн төлбөр, хүү төлөх хугацааг хойшлуулах, 50 хувь нь НДШ-ийн төлбөрийг хөнгөлөх, төлөх хугацааг хойшлуулах, 47 хувь нь санхүүгийн дэмжлэг, 44 хувь нь хөнгөлөлттэй зээл олгож бизнес, эдийн засгаа дэмжих нь зүйтэй байна гэжээ. Түүнчлэн түрээс, аж ахуйн нэгжийн ашиглалтын зардлуудад дэмжлэг үзүүлэх, ажиллагсдын цалин

олгоход дэмжлэг үзүүлэх, төрөөс батлан дааж бизнес эрхлэгчдэд бага хүүтэй, урт хугацааны зээл олгох зэргийг нэрлэсэн байна.

Судалгааны үр дүнгээс харахад хатуу хөл хорионы хугацааг сунгасан тохиолдолд эдийн засгийн болон экспортын гол салбаруудын үйл ажиллагааг сэргээх, хэвийн явуулах; ААН-үүдийг ажлын байраа хадгалах чиглэлд нь дэмжлэг үзүүлэх; цар тахлаас үүдэн ихээхэн хохирол амссан хувиараа бизнес эрхлэгчид болон жижиг бизнес эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд чиглэгдсэн санхүүгийн дэмжлэг үзүүлэх багц арга хэмжээг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна. Тухайлбал:

1. Үйл ажиллагаа бүрэн зогссон, ихээр хязгаарлагдсан салбарын бизнест санхүүгийн дэмжлэг үзүүлэх
2. Богино хугацааны ажилгүйдлийн эсрэг чиглэсэн санхүүгийн дэмжлэг үзүүлэх
3. Жижиг дунд бизнес эрхлэгчид болон хувиараа бизнес эрхлэгчид, цар тахлын нөлөө хүндээр туссан салбарын ААН-үүдэд баталгаа шаардахгүй, хүүгүй болон маш бага хүүтэй зээл олгох
4. Цар тахлын нөлөөллийн улмаас борлуулалтын орлогогүй болон орлого нь маш доогуур байгаа ААН-үүдийн цалингийн зардалд татаас өгөх
5. Нөлөөлөлд өртсөн ААН-үүдийн нийгмийн даатгалын шимтгэлийг хойшлуулах буюу чөлөөлөх, тухайлбал бичил жижиг ААН-ийн нийгмийн даатгалын шимтгэлийг 100 хувь төлөх
6. Нөлөөлөлд ихээр өртсөн салбарын жижиг дунд ААН-ийн тогтмол зардлыг санхүүжүүлэх, түрээсийн төлбөрийг хөнгөх, чөлөөлөхөд дэмжлэг үзүүлэх
7. Нөлөөллийн улмаас бизнес нь доголдсон аж ахуйн нэгжүүдэд зээлийн үндсэн ба хүүгийн төлбөрийн татаас өгөх
8. Нөлөөлөлд өртсөн бизнес эрхлэгчдийг санхүүгийн хөрвөх чадвараар хангах зорилгоор олгох банкны зээлийн хүүг бууруулахад дэмжлэг үзүүлэх

Нэг. Хатуу хөл хорионы бизнест үзүүлж буй нөлөө

Үйл ажиллагаанд үзүүлж буй нөлөө

2020 оны 11 сарын 12 өдрөөс бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжин, хатуу хөл хорио тогтоосноос хойш аж ахуйн нэгжүүд хэрхэн үйл ажиллагаагаа явуулж байгаа тухай тодруулан асуухад нийт судалгаанд оролцогсдын 66 хувь нь бүрэн зогссон, 22 хувь нь хязгаарлагдмал хүрээнд ажиллаж байгаа, 10 хувь нь зайнаас ажиллаж байгаа гэсэн бол дөнгөж 2 хувь нь хэвийн үйл ажиллагаагаа явуулж байна гэж хариулжээ. (Зураг 1.1).

Зураг 1.1. Хөл хорионы үед аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаа явуулж буй байдал



Үйл ажиллагаа явуулж буй байдлыг салбараар нь ангилан харвал хүнсний бус үйлдвэрлэл, аялал жуулчлал, үйлчилгээний салбарын аж ахуйн нэгжийн 80 орчим хувь нь үйл ажиллагаагаа бүрэн зогсоосон байна гэжээ. Барилгын салбарын бизнес эрхлэгчдийн 75 хувь нь бизнесээ зогсоосон гэж хариулсан бол худалдаа, дотоод тээвэр, боловсролын салбарын бизнес эрхлэгчдийн 60 орчим хувь нь бизнесээ бүрэн зогсоож, үйл ажиллагаа явуулахгүй байна. (Зураг 1.2)

Зураг 1.2. Хөл хорионы үед аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаа явуулж буй байдал, *салбараар*

Судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдээс хэрэв хөл хорионы үед халдвар хамгааллын дэглэмийг сахин, үйл ажиллагаагаа зохион явуулах боломжтой бол хэрхэн үйл ажиллагаагаа зохион байгуулан ажиллах тухай тодруулахад 35 хувь нь компанийн зүгээс халдвар хамгааллын дэглэмийн хүрээнд тодорхой, ойлгомжтой дүрэм журам гарган нарийн мөрдөж үйл ажиллагаагаа хэвийн явуулах сонирхолтой байна гэжээ. Харин 32 хувь нь халдвар хамгааллын дэглэмийн хүрээнд ажиллагсдын тоог бууруулан ажиллах, 14 хувь нь хүчин чадлаа тодорхой хувиар бууруулан ажиллах боломжтой байна. Өөрөөр хэлбэл нийт судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдийн 95 хувь нь өөрсдөө цар тахлаас сэргийлэх нарийн шаардлага, дүрэм журмыг боловсруулан, түүнийгээ дагаж мөрдөн тодорхой түвшинд үйл ажиллагаагаа явуулах сонирхолтой байна. (Зураг 1.3)

Зураг 1.3. Хөл хорионы үед халдвар хамгааллын дэглэмийг сахин үйл ажиллагаагаа зохион байгуулах боломжтой хувилбарууд



Ажлын байр, цалинд үзүүлж буй нөлөө

Судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдээс хатуу хөл хорионы дэглэм тогтоосноос хойш өөрийн компанийн нөөц боломжоор ямар хугацаанд ажлын байрны тоог өөрчлөхгүй хадгалж үлдэх боломжтой тухай тодруулан асуухад 53 хувь нь 1 сараас бага хугацаа гэсэн бол 31 хувь 1-3 сарын хугацаанд ажлын байрыг хадгалах боломжтой гэжээ. Өөрөөр хэлбэл нийт судалгаанд оролцогсдын 84 хувь нь 3 сарын хугацаанд ямар нэгэн байдлаар ажлын байрны тоог цөөлнө гэжээ. (Зураг 1.4)

Зураг 1.4. Аж ахуйн нэгжүүд өөрийн нөөцөөр ажлын байраа хадгалах боломжтой хугацаа



Өөрийн нөөцөөр ажлын байраа хадгалах боломжтой хугацааг аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны салбараар нарийвчлан авч үзвэл аялал жуулчлал, барилга, хүнсний бус үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын бизнес эрхлэгчдийн 60 орчим хувь нь 1 сар болон түүнээс бага хугацаанд ажлын байраа хадгална гэжээ. Мөн дээрх салбарын аж ахуйн нэгжүүдийн 90 орчим хувь нь хөл хорио 3 сараас дээш хугацаанд үргэлжилсэн тохиолдол ажлын байрыг хадгалах боломжгүй гэж хариулжээ.

Харин уул уурхай, мэдээлэл технологи, харилцаа холбоо, эрүүл мэнд, хүнсний үйлдвэрлэлийн салбарын бизнес эрхлэгчид бусад салбаруудтай харьцуулахад ажлын байрны тоог хадгалах боломжит хугацаа харьцангуй урт байна. (Зураг 1.5).

Зураг 1.5. Аж ахуйн нэгжүүд өөрийн нөөцөөр ажлын байраа хадгалах боломжтой хугацаа, *салбараар*



Одоо мөрдөгдөж байгаа хөл хорионы дэглэм ажлын байранд хэрхэн нөлөөлж байгаа, түүнчлэн хөл хорионы дэглэм үргэлжилбэл бизнес эрхлэгчдэд хэрхэн нөлөөлөх талаар тодруулах зорилгоор хөл хорионы дэглэмийн хугацааг 3 шатлалтайгаар авч, ажлын байр дах нөлөөллийг тодрууллаа.Үүнд:

A. 12 сарын 1-ний өдөр хүртэл үргэлжлэх: 11 сарын 12-ны өдрөөс хөл хорионы дэглэм тогтоосноос хойш аж ахуйн нэгжүүд ямар арга хэмжээ авч хэрэгжүүлсэн талаар тодруулахад 67 хувь нь ажлын байрны тоонд ямар нэг өөрчлөлт оруулаагүй байна. Харин судалгаанд оролцсон 3530 аж ахуйн нэгжийн 25 хувь нь ажлын байрны тоог бууруулсан ба нийт **7,645** ажлын байр цөөлжээ. Энэ тоог нийт идэвхтэй, бодит үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн тоогоор тооцоолбол одоогоор 152,900 ажлын байр цөөлсөн байна. (Зураг 6)

B. 2020 оны 12 сарын 31-ний өдөр хүртэл үргэлжлэх: хөл хорионы дэглэм 12 сарын 1-ний өдрөөс дахин нэг сараар сунгагдсан тохиолдолд нийт судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 46% нь ажлын байрны тоог бууруулна гэжээ. Ойролцоогоор бууруулах ажлын байрны тоог асуухад нийт **21,630** ажлын байр цөөлнө гэж хариулжээ. Энэ тоог нийт идэвхитэй, бодит үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн тоогоор тооцоолбол 432,600 ажлын байр цөөлнө гэж таамаглаж байна. Харин ажлын байраа хадгалж, ямар нэг өөрчлөлт оруулахгүй байх хариулт нь 17 хувь болж хөл хорионы"А" үеэс 50 нэгж хувиар буурчээ. Түүнчлэн "үйл ажиллагааг бүрэн зогсолт хийж бүх ажилчдаа хална" гэж судалгаанд оролцогсдын 6 хувь нь хариулсан байна. (Зураг 6)

C. 2021 оны 3 сарын 1-ний өдөр хүртэл үргэлжлэх: хөл хорионы дэглэм 12 сарын 1-ний өдрөөс эхлэн цаашид 3 сараар сунгагдсан тохиолдолд нийт судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 52 хувь нь ажлын байрны тоог бууруулах ба нийт **25,253** ажлын байр цөөлнө гэж хариулжээ. Энэ тоог нийт идэвхтэй, бодит үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн тоогоор тооцоолбол 2021 оны 3 сарын 1 өдөр хүртэл хөл хорионы үед нийт 505 мянган ажлын байр цөөлөхөөр байна. Мөн судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 30 орчим хувь нь хатуу хөл хорионы хугацааг дахин сунгасан тохиолдолд ажлын байрны тоог хэрхэн өөрчлөх тухай одоогоор шийд гаргаагүй байгаа ба нөхцөл байдлыг ажиглаж байна гэжээ. (Зураг 1.6)

Зураг 1.6. Хөл хорионы дэглэмийн ажлын байрны тоонд үзүүлж буй нөлөө



Хатуу хөл хориотой холбогдуулан нийт судалгаанд оролцсон аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдийн 28 хувь нь ажиллагсдын цалинд ямар нэг өөрчлөлт оруулаагүй, 28 хувь нь сул зогсолтоор (цалингийн 60%-иар) цалинжуулж байгаа бол 41 хувь нь цалин олгохгүй байна. (Зураг 1.7).

Зураг 1.7. Хатуу хөл хорионы дэглэмийн ажиллагсдын цалинд үзүүлж буй нөлөө



Аялал жуулчлал, хүнсний бус үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын аж ахуйн нэгжүүдэд цалингаа тавихад илүү хүндрэлтэй байгаа ба цалин олгохгүй байна гэж хариулжээ. Харин олон улсын тээвэр, уул уурхай, хүнсний үйлдвэрлэлийн аж ахуйн нэгжүүд цалингаа хэвийн олгох, зарим ажилчдаа сул зогсолтоор цалинжуулах зэргээр ажиллагсдын цалинг олгож байна. (Зураг 1.8).

Мөн хувиараа бизнес эрхлэгчдийн 74% нь цалин олгохгүй байгаа бол 14% нь цалингаа 100 хувь олгож байна.

Зураг 1.8. Хатуу хөл хорионы дэглэмийн ажиллагсдын цалинд үзүүлж буй нөлөө, *салбараар*



Аж ахуйн нэгжийн санхүүд үзүүлж буй нөлөө

Хатуу хөл хорионы үед аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдэд бэлэн мөнгө (эргэлтийн хөрөнгийн)-ний нөөц ямар хугацаанд хүрэлцээтэй байгаа талаар тодруулахад 63 хувь нь 1 сар хүрэхгүй хугацаанд, 27 хувь нь 1-3 сар хүртэл хугацаанд хүрэлцээтэй гэж хариулсан байна. (Зураг 1.9)

Зураг 1.9. Аж ахуйн нэгжүүдийн бэлэн мөнгөний нөөцийн хүрэлцээтэй хугацаа



Бэлэн мөнгөний хүрэлцээтэй хугацааг үйл ажиллагааны салбараар авч үзвэл аялал жуулчлал, барилга, хүнсний бус үйлдвэрлэл, үйлчилгээ, боловсролын салбарын аж ахуйн нэгжүүдийнх хувьд нэг сар хүрэхгүй хугацааны нөөцтэй байна гэжээ. (Зураг 1.10)

Зураг 1.10. Аж ахуйн нэгжүүдийн бэлэн мөнгөний нөөцийн хүрэлцээтэй хугацаа, *салбараар*



Нийт судалгаанд оролцсон аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдийн 72 хувь нь бизнесийн зээлтэй байна. Зээлийн хэмжээгээр ангилан авч үзвэл 40 хувь нь 100 сая төгрөг хүртэл зээлтэй бол 20 хувь нь нэг тэрбум төгрөгөөс дээш хэмжээний зээлтэй байна. (Зураг 1.11)

Мөн судалгаанд оролцсон хувиараа бизнес эрхлэгчдийн зээлийн хэмжээг нарийвчлан авч үзэхэд 67 хувь нь 50 сая төгрөг хүртэл зээлтэй байдаг байна.

Зураг 1.11. Аж ахуйн нэгжийн зээлийн хэмжээ



11 сарын 12 өдрөөс эхэлсэн хатуу хөл хорионы дэглэм аж ахуйн нэгжийн борлуулалтын орлогод хэрхэн нөлөөлж байгаа, түүнчлэн хөл хорионы дэглэм үргэлжилбэл бизнес эрхлэгчдэд хэрхэн нөлөөлөх талаар тодруулах зорилгоор хөл хорионы дэглэмийн хугацааг 3 шатлалтайгаар авч, борлуулалтын орлого дах нөлөөллийг тодрууллаа.Үүнд:

A. 12 сарын 1-ний өдөр хүртэл үргэлжлэх: 11 сарын 12-ны өдрөөс хөл хорионы дэглэм тогтоосноос хойш аж ахуйн нэгжүүдийн борлуулалтын орлого 91%-ээс дээш хэмжээгээр буурсан гэж нийт судалгаанд оролцогсдын 54 хувь нь үзжээ. Мөн 12 хувь нь 71-90% буурсан бол 10 хувь нь 51-70%-иар буурчээ. Өөрөөр хэлбэл нийт судалгаанд оролцсон аж ахуйн нэгжийн 76 хувь нь борлуулалтын орлого нь 50 ба түүнээс дээш хэмжээгээр буурсан гэжээ. (Зураг 12)
B. 2020 оны 12 сарын 31-ний өдөр хүртэл үргэлжлэх: хөл хорионы дэглэм 12 сарын 1-ний өдрөөс дахин нэг сараар сунгагдсан тохиолдолд нийт судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 60% борлуулалтын орлого 91%-ээс дээш хэмжээгээр буурна гэж таамаглаж байна. (Зураг 12)
C. 2021 оны 3 сарын 1-ний өдөр хүртэл үргэлжлэх: хөл хорионы дэглэм 12 сарын 1-ний өдрөөс эхлэн цаашид 3 сараар сунгагдсан тохиолдолд нийт судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 63 хувь нь борлуулалтын орлого 91%-аас дээш хэмжээгээр буурна гэжээ. (Зураг 1.12)

Харин хувиараа бизнес эрхлэгчдийн борлуулалтын орлогын дүнг авч үзвэл одоо мөрдөгдөж байгаа хатуу хөл хорионы үед судалгаанд оролцсон хувиараа бизнес эрхлэгчдийн 72 хувь нь борлуулалтын орлого нь 91 хувиас дээш хэмжээгээр буурсан гэж хариулжээ.

Зураг 1.12. Хатуу хөл хорионы дэглэмийн борлуулалтын орлогод үзүүлж буй нөлөө



Нэгдүгээр хэсгийн дүгнэлт

- Хатуу хөл хорио тогтоосноос хойш судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдийн 66 хувь нь бүрэн зогссон, 22 хувь нь хязгаарлагдмал хүрээнд ажиллаж байна. Үйл ажиллагаа явуулж буй байдлыг салбараар нь ангилан харвал хүнсний бус үйлдвэрлэл, аялал жуулчлал, үйлчилгээний салбарын аж ахуйн нэгжийн 80 орчим хувь нь үйл ажиллагаагаа бүрэн зогсоосон байна.
- Нийт судалгаанд оролцсон аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдийн 95 хувь нь өөрсдөө цар тахлаас сэргийлэх нарийн шаардлага, дүрэм журмыг боловсруулан, дагаж мөрдөн тодорхой түвшинд үйл ажиллагаагаа явуулах сонирхолтой байна.
- Нийт судалгаанд оролцогсдын 53 хувь нь хатуу хөл хорионы дэглэм тогтоосноос хойш компанийн өөрийн нөөц боломжоор нэг сараас бага хугацаанд ажлын байраа хадгалах боломжтой байна. Үйл ажиллагааны салбараар нарийвчлан авч үзвэл аялал жуулчлал, барилга, хүнсний бус үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын бизнес эрхлэгчдэд ажиллагсдын цалин олгох асуудал нь хүнд, зардлын дарамт болж байгаа ба эдгээр салбарын аж ахуйн нэгжүүдийн 60 орчим хувь нь 1 сар хүртэл хугацаанд ажлын байраа хадгалж, түүнээс дээш хугацаагаар хөл хорио сунгагдсан тохиолдолд ажлын байрны тоог бууруулна гэжээ.
- Хатуу хөл хориотой холбогдуулан нийт судалгаанд оролцсон аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдийн 28 хувь нь ажиллагсдын цалинд ямар нэг өөрчлөлт оруулаагүй, 28 хувь нь сул зогсолтоор (цалингийн 60%-иар) цалинжуулж байгаа бол 41 хувь нь цалин олгохгүй байна. Аялал жуулчлал, хүнсний бус үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын аж ахуйн нэгжүүдэд цалингаа тавихад илүү хүндрэлтэй байгаа ба цалин олгохгүй байна гэж хариулжээ. Харин олон улсын тээвэр, уул уурхай, хүнсний үйлдвэрлэлийн аж ахуйн нэгжүүд цалингаа хэвийн олгох, зарим ажилчдаа сул зогсолтоор цалинжуулах зэргээр ажиллагсдын цалинг олгож байна.
- Хатуу хөл хорионы үед судалгаанд оролцсон аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдийн 63 хувь нь 1 сар хүрэхгүй хугацаанд, 27 хувь нь 1-3 сар хүртэл хугацаанд бэлэн мөнгөний нөөц хүрэлцээтэй гэж хариулсан байна.
- 11 сарын 12-ны өдрөөс хөл хорионы дэглэм тогтоосноос хойш судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдийн 67 хувь нь ажлын байрны тоонд ямар нэг өөрчлөлт оруулаагүй байна. Харин судалгаанд оролцсон 3530 аж ахуйн нэгжийн 25 хувь нь ажлын байрны тоог бууруулсан ба нийт **7,645** ажлын байр цөөлжээ. Энэ тоог нийт идэвхтэй, бодит үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн тоонд үндэслэн тооцоолбол аж ахуйн нэгжүүд одоогоор 152,900 ажлын байр цөөлсөн байна.
- Хөл хорионы дэглэм 12 сарын 1-ний өдрөөс дахин нэг сараар сунгагдсан тохиолдолд нийт судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 46% нь ажлын байрны тоог бууруулах ба нийт **21,630** ажлын байр цөөлнө гэж хариулжээ. Энэ тоог нийт идэвхитэй, бодит үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн тоонд үндэслэн тооцоолбол аж ахуйн нэгжүүд нийт 432,600 ажлын байр цөөлнө гэж таамаглаж байна.
- Хөл хорионы дэглэм 12 сарын 1-ний өдрөөс эхлэн цаашид 3 сараар сунгагдсан тохиолдолд нийт судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 52 хувь нь ажлын байрны тоог бууруулах ба нийт **25,253** ажлын байр цөөлнө гэжээ. Энэ тоог нийт идэвхтэй, бодит үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн тоогоор тооцоолбол 2021 оны 3 сарын 1-ний өдөр хүртэл хугацаанд хөл хорионы үед нийт 505 мянган ажлын байр цөөлөхөөр байна.

- Нийт судалгаанд оролцсон аж ахуйн нэгжийн 54 хувь нь 11 сарын 12-ны өдрөөс хөл хорионы дэглэм тогтоосноос хойш борлуулалтын орлого нь 91 хувиас дээш хэмжээгээр буурсан ба судалгаанд оролцсон аж ахуйн нэгжийн 76 хувь нь борлуулалтын орлого нь 50 ба түүнээс дээш хэмжээгээр буурсан гэжээ. Харин хувиараа бизнес эрхлэгчдийн 72% нь борлуулалтын орлого 91 хувиас дээш хэмжээгээр буурсан гэж хариулжээ.
- Хөл хорионы дэглэм 12 сарын 1-ний өдрөөс дахин нэг сараар сунгагдсан тохиолдолд нийт судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 60% борлуулалтын орлого 91 хувиас дээш хэмжээгээр буурна гэж таамаглаж байгаа бол цаашид 3 сараар сунгагдсан тохиолдолд бизнес эрхлэгчдийн 63 хувь нь борлуулалтын орлого 91%-аас дээш хэмжээгээр буурна гэж таамаглаж байна.

Хоёр. Тулгарч буй хүндрэл ба шаардлагатай дэмжлэг

Тулгарч буй хүндрэл

Хатуу хөл хорионы дэглэм тогтоосноос хойш аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдэд үүсээд буй хүндрэл, бэрхшээлийн талаар тодруулан асуухад нийт судалгаан оролцогсдын 24 хувь нь ажлын байраа хадгалах, ажиллагсдын цалин тавих, 21 хувь нь бизнесийн зээлийн эргэн төлөлт хийх, 17 хувь нь хөл хориотой холбоотой төр, засгаас гаргаж буй шийдвэрийн ойлгомжгүй, уялдаа холбоогүй байдал гэсэн бол 16 хувь нь түрээсийн төлбөрөө төлөх нь хамгийн хүндрэлтэй байна гэж хариулжээ. (Зураг 2.1)

Зураг 2.1. Хөл хориотой холбоотой бизнест үүсээд буй хүндрэл

Хөл хорионы нөхцөл байдалд аж ахуй нэгжүүдэд үүсээд буй хүндрэлийг үйл ажиллагаа явуулж буй салбараар нь нарийвчлан авч үзвэл хүнсний бус боловсруулах үйлдвэрлэл, үйлчилгээ, аялал жуулчлал, боловсрол, барилга, уул уурхайн салбаруудын аж ахжйн нэгжүүдийн хувьд ажиллагсдын цалин олгох нь хамгийн хүндрэлтэй байна. Харин дотоодын тээвэр, хөдөө аж ахуй, дотоод худалдаа, хүнсний үйлдвэрлэлийн салбарт бизнесийн зээлийн эргэн төлөлт хүндрэлтэй байна.

Олон улсын тээврийн салбарын аж ахуйн нэгжүүдэд төр засгаас гаргаж буй шийдвэрийн ойлгомжгүй, уялдаа холбоогүй байдал хүндрэл үүсгэж байгаа бол экспортын бараа бүтээгдэхүүн олон улсын зах зээлд нийлүүлдэг аж ахуйн нэгжүүдийн хувьд гадаад түншийн гэрээний үүрэг биелүүлэхгүй байх, гэрээ цуцлах асуудал нь хамгийн их хүндрэлийг үүсгээд байна гэж хариулжээ.

Шаардлагатай дэмжлэгүүд

2020 оны 11 сарын 18-ны өдөр Засгийн газраас эдийн засгийг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай 183 тоот 23 заалт бүхий тогтоолыг баталсан. Эдгээр арга хэмжээнүүд нь аж ахуй нэгж бизнес эрхлэгчдэд бодит дэмжлэг болж байгаа эсэхийг тодруулахад судалгаанд оролцсон аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдийн давхардсан тоогоор

50 хувь нь зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийн хугацаанд өөрчлөлт оруулах нь дэмжлэг болно гэж хариулжээ. (Хүснэгт 2.1)

Хүснэгт 2.1. Засгийн газрын 183 тоот тогтоолд тусгасан арга хэмжээний дэмжлэг болсон байдал

	2020 оны 11 сарын 18-ны өдрийн Засгийн газрын 183 тоот тогтоолд тусгасан арга хэмжээний дэмжлэг болсон байдал	%
1	Банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршооноос иргэд, аж ахуйн нэгжүүдэд олгосон зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийн хугацаанд өөрчлөлт оруулах	**50%**
2	Хүнсний бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, савлалт, хүргэлт, түгээлт, борлуулалтын үйлчилгээг хэвийн явуулахад чиглэсэн арга хэмжээ	**29%**
3	Хилийн боомтуудыг халдвар, хамгааллын онцгой дэглэм, горимд бүрэн хүчин чадлаар ажиллуулах	**24%**
4	Аж ахуйн нэгжийг тендер шалгаруулалтад оролцох тэгш боломжоор хангах зорилгоор бэлэн байдал зарласан хугацаанд хүлээн авах бүх төрлийн сонгон шалгаруулалтын хугацааг сунгах	**15%**
5	Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд идэвхжүүлэх	**14%**
6	Татвар төлөгчийн улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилтээр гүйцэтгэсэн бараа, ажил, үйлчилгээний төлбөрийн авлага, бусад илүү төлөлтийг татварын өрөнд суутгах	**12%**
7	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дотоодын барааг худалдан авах	**11%**
8	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ нийлүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага, иргэний төлбөрийг түргэн шуурхай барагдуулж ажиллах	**11%**
9	Импортын оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис, амны хаалтыг импортын гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх	**9%**

Харин хатуу хөл хорионы үед аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдэд Засгийн газраас ямар төрлийн дэмжлэг шаардлагатай байгааг тодруулахад давхардсан тоогоор судалгаанд оролцогсдын 55 хувь нь татвар (НӨАТ)-ын хөнгөлөлт, чөлөөлөлт, 52 хувь нь НДШ-ийн төлбөрийг хөнгөлөх, төлөх хугацааг хойшлуулах, 50 хувь нь бизнесийн үйл ажиллагааг тодорхой хувиар үргэлжлүүлэх боломж олгох, 39 хувь нь зээлийн хүүг бууруулах, 38 хувь нь аж ахуйн нэгжийн түрээсийн зардлыг төрөөс санхүүжүүлэх шаардлагатай байна гэсэн байна. (Зураг 2.2)

Мөн нэмэлтээр ямар дэмжлэг шаардлагатайг тодруулахад ажиллагсдын цалин олгоход төрөөс дэмжлэг үзүүлэх, ЖДҮ зээл олгох, хүргэлтийн үйлчилгээг зөвшөөрөх, аж ахуйн нэгжийн хэмжээнээс шалтгаалан шатлалтайгаар татвараас хөнгөлөх, чөлөөлөх,цар тахлын үед төрийн хүнд суртлыг бууруулах, төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх тал дээр анхаарч ажиллах, хувиараа бизнес эрхлэгчдэд тодорхой бодит дэмжлэг үзүүлэх зэргийг нэрлэсэн байна.

Зураг 2.2. Хөл хорионы үед аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдэд шаардлагатай дэмжлэгүүд

Хөл хорионы дэглэм дууссаны дараа бизнесийн үйл ажиллагаагаа сэргээхэд Засгийн газраас ямар дэмжлэг, шийдэл шаардлагатай байгааг тодруулахад судалгаанд оролцсон аж ахуй нэгж, бизнес эрхлэгчдийн 56 хувь нь татвар (НӨАТ)-ын хөнгөлөлт, чөлөөлөлт, 54 хувь нь зээлийн төлбөр, хүү төлөх хугацааг хойшлуулах, 50 хувь нь НДШ-ийн төлбөрийг хөнгөлөх, төлөх хугацааг хойшлуулах, 47 хувь нь санхүүгийн дэмжлэг, 44 хувь нь хөнгөлөлттэй зээл олгож бизнес, эдийн засгаа дэмжих нь зүйтэй байна гэжээ. (Зураг 2.3)

Мөн хөл хорионы дараа аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаагаа хэвийн явуулахад төрийн зүгээс хүнд суртлыг бууруулан, төрийн үйлчилгээг хурдан шуурхай авах боломж нөхцөлийг бүрдүүлэн дэмжин ажиллах шаардлагатай байна гэжээ. Түүнчлэн түрээс, аж ахуйн нэгжийн ашиглалтын зардлуудад дэмжлэг үзүүлэх, ажиллагсдын цалин олгоход дэмжлэг үзүүлэх, төрөөс батлан дааж бизнес эрхлэгчдэд бага хүүтэй, урт хугацааны зээл олгох зэргийг нэрлэсэн байна.

Зураг 2.3. Хөл хорионы дараа бизнесээ сэргээхэд шаардлагатай дэмжлэгүүд

Хоёрдугаар хэсгийн дүгнэлт

- Хатуу хөл хорионы дэглэм тогтоосноор судалгаанд оролцсон аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдийн 24 хувьд ажлын байраа хадгалах, ажиллагсдын цалин тавих, 21 хувьд бизнесийн зээлийн эргэн төлөлт хийх, 17 хувьд хөл хориотой холбоотой төр, засгаас гаргаж буй шийдвэрийн ойлгомжгүй, уялдаа холбоогүй байдал, 16 хувьд түрээсийн төлбөрөө төлөх нь хамгийн хүндрэлтэй байна гэжээ. Үйл ажиллагааны салбар харгалзахгүйгээр ажлын байраа хадгалах, ажиллагсдын цалин тавих нь хамгийн тулгамдаж буй асуудал гэж нэрлэсэн байна. Мөн дотоодын тээвэр, хөдөө аж ахуй, дотоод худалдаа, хүнсний үйлдвэрлэлийн салбарт бизнесийн зээлийн эргэн төлөлт хүндрэлтэй байгаа бол олон улсын тээврийн салбарын аж ахуйн нэгжүүд төр засгаас гаргаж буй шийдвэрийн ойлгомжгүй, уялдаа холбоогүй байдал, экспортлогч компаниудад гадаад түншийн гэрээний үүрэг биелүүлэхгүй байх, гэрээ цуцлах асуудал нь хамгийн их хүндрэлийг үүсгээд байна.
- Засгийн газраас хатуу хөл хорионы үед аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдэд шаардлагатай дэмжлэгийг тодруулахад судалгаанд оролцогсдын 55 хувь нь татвар (НӨАТ)-ын хөнгөлөлт, чөлөөлөлт, 52 хувь нь НДШ-ийн төлбөрийг хөнгөлөх, төлөх хугацааг хойшлуулах, 50 хувь нь бизнесийн үйл ажиллагааг тодорхой хувиар үргэлжлүүлэх боломж олгох, 39 хувь нь зээлийн хүүг бууруулах, 38 хувь нь аж ахуйн нэгжийн түрээсийн зардлыг төрөөс санхүүжүүлэх шаардлагатай байна гэсэн байна. Мөн нэмэлтээр ажиллагсдын цалин олгоход төрөөс дэмжлэг үзүүлэх, хүргэлтийн үйлчилгээг зөвшөөрөх, аж ахуйн нэгжийн хэмжээнээс шалтгаалан шатлалтайгаар татвараас хөнгөлөх, чөлөөлөх, цар тахлын үед төрийн хүнд суртлыг бууруулах, төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх тал дээр анхаарч ажиллах, хувиараа бизнес эрхлэгчдэд тодорхой бодит дэмжлэг үзүүлэх зэргийг нэрлэсэн байна.
- Харин хөл хорионы дэглэм дууссаны дараа бизнесийн үйл ажиллагаагаа сэргээхэд бизнес эрхлэгчдийн 56 хувь нь татвар (НӨАТ)-ын хөнгөлөлт, чөлөөлөлт, 54 хувь нь зээлийн төлбөр, хүү төлөх хугацааг хойшлуулах, 50 хувь нь НДШ-ийн төлбөрийг хөнгөлөх, төлөх хугацааг хойшлуулах, 47 хувь нь санхүүгийн дэмжлэг, 44 хувь нь хөнгөлөлттэй зээл олгож бизнес, эдийн засгаа дэмжих шаардлагатай байна гэжээ. Мөн хөл хорионы дараа аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаагаа хэвийн явуулахад төрийн зүгээс хүнд суртлыг бууруулан, төрийн үйлчилгээг хурдан шуурхай авах боломж нөхцөлийг бүрдүүлэн дэмжин ажиллах, түрээс, аж ахуйн нэгжийн ашиглалтын зардлууд, ажлын байраа хадгалахад дэмжлэг үзүүлэх, төрөөс батлан дааж бизнес эрхлэгчдэд бага хүүтэй, урт хугацааны зээл олгох шаардлагатай байна гэж үзсэн байна.

Гурав. Оролцогчдын мэдээлэл

Судалгааг Улаанбаатар хот, орон нутгийн бизнес эрхлэгчдийн дунд цахим хэлбэрээр 2020 оны 11 сарын 23-25-ны өдрүүдэд явуулсан бөгөөд MYXAYT-ын гишүүн болон гишүүн бус 3530 аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдийг хамруулав.

Нийт судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдийг үйл ажиллагааг явуулж буй байршлаар нь ангилан харвал 82% нь Улаанбаатар, 18% нь орон нутагт байна. Салбараар нь харвал 27% нь үйлчилгээ, 18% нь дотоод худалдаа, 9% гадаад худалдаа, барилга, 8% нь хүнсний бус үйлдвэр, 7% нь хүнсний үйлдвэр байна.

Ажиллагсдын тоогоор нь авч үзвэл 54% нь 19 хүртэлх ажилтантай, 24% нь 20-199 хүртэлх ажилтантай, 13% нь хувиараа бизнес эрхлэгч, 8% нь 200- аас дээш ажилтантай байна. Судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдийн 41% нь 100 саяас доош орлоготой бизнес эрхлэгчид, 37% нь 101- 1 тэрбум төгрөгийн орлоготой, 21% нь нэг тэрбумаас дээш орлоготой томоохон аж ахуйн нэгжүүд байна. Бизнесийн үйл ажиллагаа явуулсан хугацаагаар нь авч үзвэл 34% нь 10-с дээш жил бизнес эрхэлсэн үйл ажиллагаа нь тогтворжсон аж ахуйн нэгжүүд байгаа бол 6% нь нэг жилээс бага хугацаанд үйл ажиллагаа явуулж буй шинэ бизнес эрхлэгчид байна.